



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/421

Хэрлэн сум


Ахмадын урлагийн 4 дүгээр наадамд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 27 дугаар хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Ахмадын хороонд ахмадуудын нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, уламжлалт ёс заншил, авьяас чадварыг нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Ахмадын урлагийн 4 дүгээр наадам”-ыг зохион байгуулах зардалд 6,000,000 (зургаан сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Хэнтийн түүх бидэнд чухал арга хэмжээний зардал”-аас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ